



НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АКТ

Бага тойруу 13/1, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
Цахим шуудан: undeg@ndaatgal.mn,
Цахим хуудас: <http://www.ndaatgal.mn>

2024.12.12 № 32/00039

ХЭНТИЙ АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗАРТ

Тэтгэврийн олголт зогсоох тухай

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр баталсан удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн хэрэгжилтийг 2018-2023 онд шинээр болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан нийт 2420 иргэний тэтгэвэр тогтоолгосон баримтын үндэслэлийг, мөн давхардсан тоогоор нийт 76606 тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтыг мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөл, анхан шатны баримтад тулгуурлан шалгалаа.

Шалгалтаар Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалтад заасан ажилласан жилийн болзол хангаагүй, хуурамч бичиг баримт бүрдүүлж, хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэврийг илүү тогтоож олгосон зөрчил илрэв.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь заалт, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

Нэг. Хуурамч баримт бүрдүүлэн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон Зундуйн Нарантуяа/УГ64091808/-ийн тэтгэврийн олголтыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тэтгэврийн олголтыг түдгэлзүүлэн зогсоосугай. (Хавсралт-1)

Хоёр. Энэхүү актын хавсралтад заасан тэтгэвэр авагчийн мэдээллийг тэтгэврийн программд зогсоох хөдөлгөөнөөр бүртгэж, хувийн хэрэгт буй баримтын хадгалалт хамгаалалд хяналт тавьж, бүрэн гүйцэд байдлыг хангаж ажиллахыг Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс /А.Октябрь/-т хариуцуулсугай.

Гурав. Хуурамч баримт бүрдүүлж тэтгэвэр тогтоолгосон тэтгэвэр авагч З.Нарантуяатай Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтын дагуу уулзаж зөрчлийг танилцуулан тэмдэглэл хөтлөн, илүү олгогдсон тэтгэврийг

00000097


санд нөхөн төлүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн дотор Хяналт шалгалтын газарт ирүүлэхийг Захиргаа, хяналтын хэлтэс /Н.Цолмонбаяр/-т, Санхүү бүртгэлийн хэлтэс /А.Эрдэнэчимэг/-т, Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтэс /А.Октябрь/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Энэхүү актын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газар /Н.Нямхатан/-т хариуцуулсугай.

АКТ


ТОГТООСОН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН
УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ


Б.ЗУЛ
Б.БАТСУУРЬ
УЛСЫН БАЙЦААГЧ
А.СОЖИДМАА
Ж.ГАНЗОРИГ

ЗӨВШӨӨРСӨН:

ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА


Н.НЯМХАТАН
ЗАХИРГАА, ХЯНАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА
/Н.Цолмонбаяр/ Н.ЦОЛМОНБАЯР
САНХҮҮ БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА, АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ
А.ЭРДЭНЭЧИМЭГ
ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА
А.ОКТЯБРЬ

НДЕГ-ын 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
32/00039 тоот улсын ахлах байцаагчийн
актын хавсралт 1

ТЭТГЭВРИЙН ТОГТООЛТ, ОЛГОЛТОД ХИЙСЭН
ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ТӨЛБӨР, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Хэнтий аймгийн НДГазар

Илүү олгосон /Нөхцөл/

д/д	Тэтгэвэр авагчийн		Зөрчлийн шалтгаан	Сарын тэтгэвэр			Тэтгэвэр илүү авсан сарын тоо	Төлбөр, зөрчлийн дүн	Шийдвэрлэсэн нь	Тайлбар
	Хувийн хэргийн дугаар (оршин суугаа сум, дүүрэг, баг, хороо)	Овог нэр		шалгахас өмнө авч байсан	шалгаснаар олгох	Зөрүү				
1	ӨН-31396 Биндэр сум /2015.07.03/	Зундуй Нарантуяа /УГ64091808/	НДСОТХуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дахь заалтыг зөрчиж хуурамч бичиг баримт бүрдүүлэн хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон.	650 000	540 000	110 000	112	19 852 978	Зогсоох өөрчлөн тогтоох	
	ДҮН							19 852 978		



 Б.Зул
 Б.Батсуурь
 А.Сожидмаа
 Ж.Ганзориг

Жагсаалт гаргасан:
НДЕГ-ын Хяналт, шалгалтын газар
ахлах мэргэжилтэн, улсын ахлах
байцаагч

Улсын ахлах байцаагч

Улсын байцаагч